



## ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах дараах үндэслэл, шаардлага байна.

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.2.1.халдварт болон халдварт бус өвчинөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Импорт орлох эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих бодлого баримтална”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.8.6. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих” гэж тус тус заасан.

#### **1.2.Практик шаардлага**

Дэлхий нийтэд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархалт 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 225 улс орон, нутаг дэвсгэрийг хамарч, 424,8 сая хүн өвчилж, 5,9 сая хүн нас барж, 355,8 сая хүн эмчлэгдэн бүрэн эдгэсэн байна.

Манай улсад Коронавируст халдвар (КОВИД-19) 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 525 тохиолдол шинээр батлагдаж, нийт батлагдсан тохиолдлын тоо 903,150 бүртгэгдсэн байна. Коронавируст халдвар (Ковид-19)-ын шинэ хувилбар болох “Омикрон” хувилбарын тархалт манай улсад буурч байгаа боловч дэлхийн бусад улс оронд тархалт өндөр хэвээр байна. КОВИД-19 батлагдсан 3409 тохиолдол Улаанбаатар хот, 21 аймгийн нийт 44 эрүүл мэндийн байгууллагад хэвтэн эмчлүүлж байна. Хэдийгээр манай улсад халдварын тохиолдол буурч байгаа боловч эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур,

ариутгал, халдвартгүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдлыг хангах бодит хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэхээр импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан бөгөөд үйлчлэх хугацаа 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болсон.

Хуулийн үйлчлэх хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 132 дугаар тогтоолын дагуу нийт **3872 бүрдүүлэлтээр, 257 аж ахуйн нэгжийн, 615 нэр төрлийн 1,109,099,984,492 төгрөгийн** үнийн дүн бүхий оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис зэрэг жагсаалтад туссан бараанд ногдуулсан **32,6 тэрбум төгрөгийн** гаалийн албан татвараас чөлөөлсөн нь нөөцийг тасралтгүй бүрдүүлэх, үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулах эрх зүйн томоохон дэмжлэг болж чадсан.

Иймд цар тахлын хүнд цаг үед Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг гаалийн албан татвараас үргэлжлүүлэн чөлөөлөх нь зүйтэй байна.

Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрлэлийн түүхий эд 100 хувь импортоос хамааралтай, үйлдвэрлэл эрхлэгчид эргэлтийн хөрөнгө дутмаг, банкны зээлийн хүү өндөр, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өссөн зэргээс хамаарч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ өсөх, үйл ажиллагаа доголдох хүндрэл үүсэж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрүүд Гаалийн албан татварт **2019 онд 515,862,942 төгрөг, 2020 онд 805,026,323 төгрөг, 2021 онд 1,066,365,609 төгрөг** тус тус төлсөн байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Импорт орлох эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих бодлого баримтална” гэсэн заалтын хүрээнд үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өртгийг бууруулах, үйл ажиллагааг дэмжихийн тулд тэдний импортлон оруулж байгаа түүхий эд, савлагааны материал, туслах материалын гаалийн албан татварт хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлахад Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд нэн шаардлагатай нөөц бүрдүүлэх, эрсдэл багатай даван туулахад төрийн зүгээс холбогдох татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх зохицуулалтын хувилбар нь оновчтой, болох талаар судалгааны зөвлөмж гарсан бөгөөд Татварын ерөнхий хуулийн 3.1-д “tatvarыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй.” гэж заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай боллоо.

## **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг гурван зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг 2022 оныг дуустал гаалийн албан татвараас чөлөөлөх талаар, 2 дугаар зүйлээр гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтыг Засгийн газар батлахаар, 3 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус зохицуулахаар тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна.

Коронавируст халдварт (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нөөцийн бэлэн байдлыг тасралтгүй хангах, тархалтаас үүдэлтэй эдийн засгийн сорилтыг даван туулахад иргэн, аж ахуйн нэгжид бодит дэмжлэг болно.

Мөн төрөөс баримталж буй бодлогын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг туштай дэмжих, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулах, импортоос хамааралтай байдлыг бууруулах, эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэх зэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэхэд нөлөөлнө.

### **Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай хууль тогтоомжууд байхгүй болно.



## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах дараах үндэслэл, шаардлага байна.

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.2.1.халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Импорт орлох эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих бодлого баримтална”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.8.6. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих” гэж тус тус заасан.

#### 1.2.Практик шаардлага

Дэлхий нийтэд коронавируст халдвэр /КОВИД-19/-ын цар тахлын тархалт 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 225 улс орон, нутаг дэвсгэрийг хамарч, 424,8 сая хүн өвчилж, 5,9 сая хүн нас барж, 355,8 сая хүн эмчлэгдэн бүрэн эдгэсэн байна.

Манай улсад Коронавируст халдвэр (КОВИД-19) 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 525 тохиолдол шинээр батлагдаж, нийт батлагдсан тохиолдлын тоо 903,150 бүртгэгдсэн байна. Коронавируст халдвэр (Ковид-19)-ын шинэ хувилбар болох “Омикрон” хувилбарын тархалт манай улсад буурч байгаа боловч дэлхийн бусад улс оронд тархалт өндөр хэвээр байна. КОВИД-19 батлагдсан 3409 тохиолдол Улаанбаатар хот, 21 аймгийн нийт 44 эрүүл мэндийн байгууллагад хэвтэн эмчлүүлж байна. Хэдийгээр манай улсад халдварын

тохиолдол буурч байгаа боловч эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдлыг хангах бодит хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэхээр импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан бөгөөд үйлчлэх хугацаа 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болсон.

Хуулийн үйлчлэх хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 132 дугаар тогтоолын дагуу нийт **3872 бүрдүүлэлтээр, 257 аж ахуйн нэгжийн, 615 нэр төрлийн 1,109,099,984,492** төгрөгийн үнийн дүн бүхий оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис зэрэг жагсаалтад туссан бараанд ногдуулсан **68,9 тэрбум** төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн нь нөөцийг тасралтгүй бүрдүүлэх, үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулах эрх зүйн томоохон дэмжлэг болж чадсан.

Иймд цар тахлын хүнд цаг үед Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг гаалийн албан татвараас үргэлжлүүлэн чөлөөлөх нь зүйтэй байна.

Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрлэлийн түүхий эд 100 хувь импортоос хамааралтай, үйлдвэрлэл эрхлэгчид эргэлтийн хөрөнгө дутмаг, банкны зээлийн хүү өндөр, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өссөн зэргээс хамаарч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ өсөх, үйл ажиллагаа доголдох хүндрэл үүсэж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрүүд Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-т 2019 онд 1,049,658,078 төгрөг, 2020 онд 1,650,537,094 төгрөг, 2021 онд 2,255,754,318 төгрөгийн татвар төгрөг тус тус төлсөн байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Импорт орлох эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих бодлого баримтална” гэсэн заалтын хүрээнд үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өртгийг бууруулах, үйл ажиллагааг дэмжихийн тулд тэдний импортлон оруулж байгаа түүхий эд, савлагааны материал, туслах материалын нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татварт хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлахад Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд нэн шаардлагатай нөөц бүрдүүлэх, эрсдэл багатай даван туулахад төрийн зүгээс холбогдох татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх зохицуулалтын хувилбар нь оновчтой болох талаар судалгааны зөвлөмж гарсан бөгөөд Татварын ерөнхий хуулийн 3.1-д “татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй.” гэж заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай боллоо.

## **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг гурван зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг 2022 оныг дуустал гаалийн албан татвараас чөлөөлөх талаар, 2 дугаар зүйлээр гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтыг Засгийн газар батлахаар, 3 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус зохицуулахаар тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна.

Коронавируст халдварт (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нөөцийн бэлэн байдлыг тасралтгүй хангах, тархалтаас үүдэлтэй эдийн засгийн сорилтыг даван туулахад иргэн, аж ахуйн нэгжид бодит дэмжклэг болно.

Мөн төрөөс баримталж буй бодлогын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг тууштай дэмжих, иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулах, импортоос хамааралтай байдлыг бууруулах, эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэх зэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэхэд нөлөөлнө.

### **Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай хууль тогтоомжууд байхгүй болно.

-----оОо-----